SINCE 1937

ГУТАЛ ХК

# “ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

ХУРАЛ 2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН 10 ЦАГТ
КОМПАНИЙН ЗАХИРГААНЫ БАЙРАНД БОЛНО

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

УТАС: 11 341678, 99044612

# ГАРЧИГ

1. "Гутал" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол
2. "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
3. "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлууд
4. Хувьцаа эзэмшигчдийн танилцах материалын жагсаалт
5. "Гутал" ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан,тэдгээрийн талаарх ТУЗ-н дүгнэлт
6. "Гутал" ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
8. "Гутал" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийн төсөл
9. "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүд
10. "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал авах хуудас
11. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэрийн хуулбар

**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 20 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг**

**зарлан хуралдуудах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”-ын 2.2 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 29-ний Лхагва гаргийн 10 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 67 тоот “Гутал” ХК-ийн байрны 2 давхарт байрлах ТУЗ-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
   - 2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
   - 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
   - 2.3 2025 оны ногдол ашиг хуваарилах тухай танилцуулах;
   - 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 8-ний өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөр, олон нийтэд зарлах өдрийг 2026 оны 03 дугаар сарын 23-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 23-ний өдөр болон 2026 оны 04 дүгээр сарын 07-ний өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ний өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн болон Гутал ХК-ийн цахим хуудаст байршуулах, 2026 оны 03 дугаар сарын 25-ний

өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерын компанид хүргүүлэх, 2026 оны 03 дугаар сарын 23-ний өдөр болон 2026 оны 04 дүгээр сарын 07-ний өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио , телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдуулахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

   6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийн хуулбар;

   6.2 Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга;

   6.3 Хурлын санал хураах хуудас;

   6.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

   6.5 Хурлын зар;

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр, хурлын дэгийг Хавсралт №2-оор, танилцах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №3-аар, ТУЗ-ийн төсвийн төслийг Хавсралт №4-өөр тус тус баталсугай

8. Эчнээ санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн дарга Б.Батбилэгт даалгасугай.

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

    Дарга: Э.Бадамгарав

    Гишүүд: Б.Байгаль, Ш.Ичинхорлоо

11. Хурал зохион байгуулах комиссын даргаар О.Марал-Эрдэнэ томилсугай.

12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурлын зохион байгуулах комисст даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** **Б.БАТБИЛЭГ**

9020040448 2075423
ULAANBAATAR MONGOLIA

*Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 0[illegible] сарын [illegible]-гий өдрийн*
*2 тоот тогтоолын Хавсралт №2*

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
9020040448 2075423
ULAANBAATAR MONGOLIA

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг**

| № | Хэлэлцэх асуудал | Хугацаа /минут/ |
|---|---|---|
| 1. | Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах, ирц бүртгэх | 15 |
| 2. | Хурлын ирцыг мэдээлэх, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулах | 3 |
| 3. | Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж хурлаар хэлэлцэх асуудлууд хурлын дэгийг танилцуулах | 5 |
| 4. | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг дараалалын дагуу танилцуулан, нэр дэвшигч бүрийг танилцуулан асуулт хариулт явуулах, санал сонсох, саналын хуудсыг хурааж авах | 45 |
| 5. | Хурлын завсарлага, хувьцаа эзэмшигчид цай кофегоор үйлчлэх | 20 |
| 6. | Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах | 5 |
| 7. | Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах | 5 |
| 8. | Хурлын дарга хурлыг хаах | 3 |

Хурал зохион байгуулах комисс

*Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 сарын 20-ний өдрийн*
*2 тоот тогтоолын Хавсралт №3*

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
9020040448 2075423
ULAANBAATAR MONGOLIA

Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тэдгээрийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
3. Компанийн ТУЗ-ийн 2026 оны төсвийн төсөл
4. Санал хураах хуудас
5. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан шийдвэр
6. "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүд
7. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл танилцуулга, нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт
8. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

Хурал зохион байгуулах комисс

**"ГУТАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг батлах;
4. 2025 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах.

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Гутал ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2025 оны 12 сарын 31 өдөр
(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 |
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1,855,924,332.40 | 713,656,812.05 |
| 1.1.2 | Дансны авлага | 723,543,394.98 | 947,232,304.11 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 2,130,921.70 | 1,644,894.18 |
| 1.1.4 | Бусад авлага | 1,643,218,589.92 | 1,080,570,795.36 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 2,914,611,899.89 | 5,846,329,498.78 |
| 1.1.6 | Бараа материал | 54,612,332.68 | 54,542,334.68 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 700,000.00 | 700,000.00 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус | | |
| 1.1.10 | | | |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **7,194,741,471.57** | **8,644,676,639.16** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 7,076,051,686.82 | 7,012,429,725.23 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | | |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 25,216,600.00 | 25,216,600.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 67,517,785.73 | 86,914,453.17 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | | | |
| | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **7,168,786,072.55** | **7,124,560,778.40** |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,363,527,544.12** | **15,769,237,417.56** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **ӨР ТӨЛБӨР** | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 65,370,407.50 | 43,087,550.38 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 32,027,620.85 | 35,439,088.28 |
| 2.1.1.3 | Татварын өр | 248,166,343.47 | 289,891,853.72 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | - | - |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 1,129,724,823.00 | 1,284,269,277.08 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 275,740,753.94 | 307,635,091.81 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 10,763,361.32 | 10,763,361.32 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус | | |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.12** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,761,793,310.08** | **1,971,086,222.59** |
| | | | |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,761,793,310.08** | **1,971,086,222.59** |
| 2.3 | Эздийн өмч | | |
| **2.3.1** | **Өмч : - төрийн** | | |
| 2.3.2 | -хувийн | 161,868,400.00 | 161,868,400.00 |
| 2.3.3 | -хувьцаа | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | (13,823,880.00) | (13,823,880.00) |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 90,744,710.50 | 90,744,710.50 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 8,364,780,001.66 | 8,364,780,001.66 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 1,369,000.00 | 1,369,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 3,996,796,001.88 | 5,193,212,962.81 |
| 2.3.10 | Тайлангийн үеийн | | |
| 2.3.11 | Өмнөх үеийн | | |
| **2.3.12** | **Эздийн өмчийн дүн** | **12,601,734,234.04** | **13,798,151,194.97** |
| **2.4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **14,363,527,544.12** | **15,769,237,417.56** |

Ерөнхий захирал Ц.Төмөр

Нягтлан бодогч Ц.Амаржаргал

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ 9020040448 ☏ 2075423 ULAANBAATAR MONGOLIA

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Гутал ХК
(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

2025 оны 12 сарын 31 өдөр

| | Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **161,868,400.00** | **13,823,880.00** | **90,744,710.50** | **8,364,780,001.66** | **-** | **53,596,996.87** | **1,949,567,598.82** | **10,606,733,827.85** |
| 18 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | 3,423,520,953.25 | 3,423,520,953.25 |
| 19 | **Залруулсан үлдэгдэл** | **161,868,400.00** | **13,823,880.00** | **90,744,710.50** | **8,364,780,001.66** | **-** | **53,596,996.87** | **1,949,567,598.82** | **10,606,733,827.85** |
| 20 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | | | | | | | - | - |
| 21 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | - |
| 22 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | -52,227,996.87 | 376,309.02 | (51,851,687.85) |
| 23 | Зарласан ногдол ашиг | | | | | | | 3,074,986,523.60 | 3,074,986,523.60 |
| 24 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | - |
| 25 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **161,868,400.00** | **13,823,880.00** | **90,744,710.50** | **8,364,780,001.66** | **-** | **1,369,000.00** | **3,996,796,001.88** | **12,601,734,234.04** |
| 26 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | | - | - |
| 27 | **Залруулсан үлдэгдэл** | **161,868,400.00** | **13,823,880.00** | **90,744,710.50** | **8,364,780,001.66** | **-** | **1,369,000.00** | **3,996,796,001.88** | **12,601,734,234.04** |
| 28 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | | | | | | | 5,087,511,807.27 | 5,087,511,807.27 |
| 29 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | | - |
| 30 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | 0.00 | (820,146.34) | (820,146.34) |
| 31 | Зарласан ногдол ашиг | | | | | | | 3,890,274,700.00 | 3,890,274,700.00 |
| 32 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | | - |
| 33 | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **161,868,400.00** | **13,823,880.00** | **90,744,710.50** | **8,364,780,001.66** | **-** | **1,369,000.00** | **5,193,212,962.81** | **13,798,151,194.97** |

Ерөнхий захирал Ц.Төмөр

Нягтлан бодогч Ц.Амаржаргал

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
9020040448 ф. 2075423
ULAANBAATAR MONGOLIA

# ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 31 өдөр

Гутал ХК
(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | | |
| 2 | Борлуулалтын өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 6,834,413,438.64 | 7,832,081,840.54 |
| 4 | Түрээсийн орлого | 266,269,447.91 | 643,208,794.76 |
| 5 | Хүүний орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | 91,690,668.25 |
| 8 | Бусад орлого | | |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 2,697,173,584.04 | 2,963,132,693.58 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | | |
| 11 | Санхүүгийн зардал | 55,767,849.80 | 23,665,667.20 |
| 12 | Бусад зардал | -15,622,182.57 | 5,608,419.65 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 351,997.36 | -105,246.30 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | **4,332,471,267.50** | **5,585,686,116.12** |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | 424,873,230.37 | 498,174,308.85 |
| 19 | Орлогын татварын зардал | **3,907,598,037.13** | **5,087,511,807.27** |
| 20 | **Татварын дараах ашиг алдагдал** | | |
| 21 | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал** | **3,907,598,037.13** | **5,087,511,807.27** |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал** | | |
| 23 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | |
| | Бусад олз (гарз) | **3,907,598,037.13** | **5,087,511,807.27** |
| 24 | **Орлогын нийт дүн** | | |
| 25 | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

Ерөнхий захирал Ц.Төмөр

Нягтлан бодогч Ц.Амаржаргал

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
9020040448 2075423
ULAANBAATAR MONGOLIA

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гутал ХК
(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

2025 оны 12 сарын 31 өдөр
(төгрөгөөр)

| | ҮЗҮҮЛЭЛТ | 2024.12.31 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 7,798,743,302.03 | 8,762,244,171.65 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 7,796,136,008.03 | 8,672,244,171.65 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| | Даатгалын нөхвөрөө хүлээн авсан мөнгө | | |
| | Буцаан авсан албан татвар | | |
| | Татаас санхүүжилтийн орлого | | |
| | Бусад орлого | 2,607,294.00 | 90,000,000.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 3,983,389,779.49 | 4,320,393,708.55 |
| | Ажилчдад төлсөн | 532,873,065.91 | 694,080,868.57 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 125,033,000.00 | 147,094,555.57 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | | 1,874,151,087.78 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 693,081.82 | |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | |
| | Хүүний төлбөрт төлсөн | | |
| | Татварын байгууллагад төлсөн | 1,267,272,078.78 | 1,536,134,014.07 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | | |
| | Бусад мөнгөн зарлага | 2,057,518,552.98 | 68,933,182.56 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **3,815,353,522.54** | **4,441,850,463.10** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 3,345,856,081.40 | 3,487,254,650.67 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 550,000.00 |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| | Бусад урт хугацааны хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөл | 341,000,000.00 | 186,636,780.28 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 125,060,459.56 | 385,455,970.50 |
| | Хугацаатай хүүтэй хадгаламж | 2,879,795,621.84 | 2,914,611,899.89 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 5,889,416,027.92 | 7,110,769,847.26 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 13,854,545.46 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| | Хугацаатай хүүтэй хадгаламж | 2,914,611,899.89 | 5,846,329,498.78 |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,974,804,128.03 | 1,250,585,803.02 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний** | **(2,543,559,946.52)** | **(3,623,515,196.59)** |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 1,660,432.99 | 7,461,150.78 |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 700,000.00 |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлэ | - | |
| | Төрөл бүрийн хандив | | |
| | Бусад мөнгөн орлого | 1,660,432.99 | 6,761,150.78 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 93,398,212.42 | 1,968,063,937.64 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 59,136,960.00 | 18,092,389.99 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө | | |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| | Төлсөн ногдол ашиг | 16,978,636.86 | 1,948,818,816.52 |
| | Бусад мөнгөн зарлага | 17,282,615.56 | 1,152,731.13 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(91,737,779.43)** | **(1,960,602,786.86)** |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,180,055,796.59 | (1,142,267,520.35) |
| 5 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 675,868,535.81 | 1,855,924,332.40 |
| 6 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,855,924,332.40 | 713,656,812.05 |

Захирал Ц.Төмөр

Нягтлан бодогч Ц.Амаржаргал

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ 9020040448 2075423 ULAANBAATAR MONGOLIA

“ГУТАЛ” ХК-ийн

2025 оны үйл ажиллагааны тайлагнал

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/* | 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Компанийн нэр: “Гутал” ХК<br>УБГД: 9010001024<br>Үнэт цаасны код: GTL<br>Утас: 99044612, 11-34 16 78 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Ажлын байрны түрээсийн үйл ажиллагаа |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | 2025 оны жилийн эцсийн тайлан гараагүй байгаа тул 2025 оны 2-р улирлын байдлаар бэлтгэсэн.<br>Аудит хийгдээгүй |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 1,618,684 |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Тайлан бэлтгэсэн: ТУЗ-н нарийн бичгийн дарга О.Марал- Эрдэнэ, нягтлан бодогч Ц.Амаржаргал<br>Хянасан: Ерөнхий захирал Ц.Төмөр |

| | | |
|---|---|---|
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт /мянган төгрөгөөр/* | Эргэлтийн хөрөнгө 6,127,497.9<br>Эргэлтийн бус хөрөнгө 6,960,967.5<br>Өр төлбөрийн нийт дүн 1,918,823.8<br>Эздийн өмчийн дүн 11,169,641.6 |
| | *Орлогын тайлан* | Орлого 3,960,521. 9<br>Ерөнхий удидлагын зардал 1,413,345.5<br>татвар төлөхийн өмнөх ашиг<br>2,797,204.1<br>Татварын зардал 249,003.7 |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Өмч 161,868.4<br>Халаасны хувьцаа 13,823,9<br>Нэмж төлөгдсөн капитал 90,744.7<br>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 8,364,780.0<br>Эздийн өмчийн бусад хэсэг 1,369.0<br>Хуримтлагдсан ашиг 2,564,703.4 |

| | | |
|---|---|---|
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ 2,007,301.4<br>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ (1,577,015.3)<br>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ (1,955,656.1)<br>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ (1,535,370.0) |
| | | |
| *1.1.* | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |
| | Аудит хараахан хийгдээгүй | |
| *1.2.* | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | Аудит хараахан хийгдээгүй | |
| *2.* | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| *2.1.* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Орлогын өсөлт 14.1%<br>Ашгийн маржин 62.1% |
| *2.2.* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Эргэлтийн хөрөнгийн харьцаа 3.2<br>Хөрвөх чадвар 2.6 |
| *2.3.* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | Хөрөнгийн түрээсийн зах зээлд өрсөлдөөн болон эрэлт нийлүүлэлтийн эрсдэл нөлөөлдөг. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс түрээсийн хөрөнгийг засаж сайжруулах, нэмж хөрөнгө оруулалт хийх, түрээсийн үнийг зах зээлийн дундажид барих зэргээр өрсөлдөх чавдараа нэмэгдүүлэх ажлуудыг тогтмол хэрэгжүүлж байна. |
| *2.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Санхүүгийн тайлангаас гадуурх бүртгэл байхгүй |
| *2.5.* | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байхгүй |
| *3.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |

| | |
|---|---|
| | |
| 4. | *Цалин урамшууллын мэдээлэл Цалингийн зардал 780,299.0*<br>*Шагнал урамшуулал 2,000.0* |
| | |
| 5. | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| | "Гутал" ХК нь 2025 оны хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолууд, 2024 оны жилийн эцсийн, 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг тухай бүрд олон нийтэд нээлттэй мэдээлэн ажилласан.<br><br>**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**<br><br>"Гутал" ХК нь Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 25-ний өдөр "Гутал" ХК-ийн өөрийн байрны ТУЗ-н хурлын танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 95.43% буюу 1,575,010 ширхэг хувьцааг эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигч оролцож тус хурал хүчин төгөлдөр болж хуралд дэвшүүлсэн асуудлуудыг хэлэлцэн баталсан.<br><br>**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**<br><br>2025 оны 04-р сарын 25-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-н ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгосон.ТУЗ-н ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн Т.Билэгт , Ц.Төмөр, Ч.Цэцэгмаа, Б.Батбилэг, Б.Батхишиг, Б.Баттөр ТУЗ-н хараат бус гишүүнээр Б.Жаргал, Э.Билгүүн, С.Бат-Эрдэнэ нар улиран сонгогдож ТУЗ-н бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.<br>ТУЗ нь 2025 онд нийт 3 удаа хуралдаж ТУЗ-н тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлээд байна. |
| 6. | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл.* |
| | *Түрээсийн эрэлт нийлүүлэлт болон өрсөлдөөний эрсдэл* |
| 7. | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
| | 2025 оны 12 сарын байдлаар 890 хувьцаа эзэмшигч нийт 1,618,684 ширхэг хувьцааг эзэмшиж байна. Үүнээс томоохон хувьцаа эзэмшигчдээс дурдахад:<br>Т.Билэгт -33%<br>Б.Батбилэг- 16.3%<br>Б.Батхишиг-15.79%<br>Б.Баттөр-13.36%<br>Ц.Төмөр-1.2% |

| | |
|---|---|
| 8. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. |
| 9. | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 01 дугаар тогтоолоор 2024 оны цэвэр ашиг, мөн үеийн санхүүгийн нөхцөл байдал зэргийг үндэслэн нэгж хувьцаанд 2,470 /хоёр мянга дөрвөн зуун далан мянган/ төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилахаар тогтоосон.<br>2025 оны ногдол ашгийн тооцоолол одоогоор хийгдээгүй байна. |
| 10. | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | 2025 онд ХУД, 20-р хороо, Үйлдвэрийн бүсэд нийтийн эзэмшил газарт "Гутал" ХК-ийн зүгээс улиас мод тарьж, тарсан модны арчилгааг одоог хүртэл хариуцаж ажиллаж байна. |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Цэрэндорж Төмөр

Албан тушаал: "Гутал" ХК-ийн Ерөнхий Захирал

Гарын үсэг:

Тамга: SHAREHOLDING CO. ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ 9020040448 2075423 ULAANBAATAR MONGOLIA

Огноо: 2025.12.23

Мэдээлэл бэлтгэсэн:

Овог, нэр: Очирновка Марал-Эрдэнэ

Албан тушаал: "Гутал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Дарга

Гарын үсэг:

Огноо: 2025.12.23

Овог, нэр: Цэрэндэндэв Амаржаргал

Албан тушаал: Нягтлан бодогч

Гарын үсэг: 23/XII 2025.

Огноо:

## “ГУТАЛ” ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮГНЭЛТ

### Нэг. Хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдал

2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар компанийн нийт хөрөнгө 15.7 тэрбум төгрөг байгаагаас мөнгөн хөрөнгө 0.7, түрээсийн авлага 0.5, бусад санхүүгийн хөрөнгө 5.8, нийт эргэлтийн хөрөнгө 8.6, эргэлтийн бус хөрөнгө 7.1 тэрбум байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд эздийн өмч 13.8, нийт өр төлбөр 1.9 тэрбум төгрөг байгаагаас татварын өр төлбөр 289.9, ногдол ашгийн өглөг 1284.2 сая төгрөг байна.

### Хоёр. Орлого

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа бөгөөд түрээсийн орлогыг хугацаатай хадгалуулж, хүүгийн орлого олж байна. Орлогыг дараах хүснэгтээс харж болно.

| Орлогын төрөл | 2024 | 2025 | Өсөлт /+/, бууралт /-/ | |
|---|---|---|---|---|
| | | | дүнгээр | хувиар |
| Түрээсийн орлого | 6,834.4 | 7,832.0 | 997.6 | 12.7 |
| Хүүгийн орлого | 266.2 | 643.2 | 377.0 | 58.6 |
| Бусад | | 91.7 | 91,7 | 100.0 |
| Дүн | 7,100.6 | 8,566.9 | 1,466.3 | 17.1 |

Түрээсийн орлого 1.0 тэрбум төгрөгөөр өссөн нь 2024, 2025 онд түрээсийн байр, агуулахуудыг шинээр барьж ашиглалтад оруулсан болон 2025 онд нэгж талбайн түрээсийн үнэлгээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

### 3. Зардал

Тайлант онд ерөнхий ба удирдлагын зардал өнгөрсөн оныхоос 265.9 сая төгрөгөөр өссөн нь цалин, нийгмийн даатгал, ашиглалтын зардлуудын өсөлттэй холбоотой байна.

### 4. Санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт

Компанийн 2025 оны санхүүгийн тайланд “Сэрэлт дөл Аудит” ХХК аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг компаниас ТУЗ-д ирүүлсэн дүгнэлт:

“Санхүүгийн тайлангууд нь компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол улсын хуулийн дагуу үнэн зөв илэрхийлсэн байна” гэж дүгнэсэн байна.

**5. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв**

Санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оныхоос ахицтай байна. Хөрөнгө, өр төлбөрийн харьцаа тогтвортой, цэвэр ашгийн хэмжээ тогтмол өсөлттэй байгаа.

Ерөнхий удирдлагын зардал 265.9 сая төгрөгөөр өссөн боловч нийт орлого 1,466.3 сая төгрөгөөр өсч тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээ 1,179.9 сая төгрөгөөр буюу 23.0 хувиар өссөн байна.

**6.Дүгнэлт**

Компанийн үйл ажиллагаа хэвийн явж ирсэн бөгөөд гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс өгсөн чиглэл удирдамжийн дагуу компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн гэж дүгнэж байна.

Борлуулалт болон ашгийн түвшин өссөн, хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд оногдох ашгийн хэмжээ тогтмол өсөж ирсэн зэрэгт үндэслэн дээрх дүгнэлтийг өгч байгаа болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

СЭРЭЛТ
ДОЛ АУДИТ ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2026.02.27 № СТА/26-29

танай ____________ -ны №____________-т

"ГУТАЛ" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Дүгнэлт**

Бид "Гутал" ХК-ний 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

**Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага (үргэлжлэл)**

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төловлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлыг хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь Шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- ✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдсөн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

***Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан***

Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

***Тайлангийн хэрэглээ***

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасны дагуу "Гутал" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СЭРЭЛТ ДОЛ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

**Д.АЛТАНЦЭЦЭГ**
Захирал, ММНБ

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 2 сарын 27

*"ГУТАЛ" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх*
*Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 03 сарын 02-ны*
*өдрийн ээлжит хурлын дүгнэлтийн Хавсралт №1*

## "ГУТАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

ЕРДИЙН ГИШҮҮД:

| № | ОВОГ НЭР | ТӨГССӨН СУРГУУЛЬ | ТУРШЛАГА |
|---|---|---|---|
| 1. | Цэрэндоржийн ТӨМӨР<br>1957 онд төрсөн. | 1987 онд Москва хотын Үйлдвэр Урлагын Дээд Сургуулийг Дизайнер мэргэжлээр төгссөн | o 1987-1990 онд Зоос Гоёлын Үйлдвэрт Дизайнер;<br>o 1990-1998 онд хувийн хэвшил.<br>o 2001 онд "Ди Би Интернешнл" ХХК-ийн УЗ-ийн гишүүн;<br>o 1998 оноос одоог хүртэл "Гутал" ХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байна |
| 2. | Батбаярын БАТХИШИГ<br>1981 онд төрсөн | 2003 онд АНУ-ын ВМСС-д бизнесийн удирдлага бакалавртай;<br>2009 онд Австралийн La Trobe University магистр төгссөн | o 2009-2010 онд "Энержи Ресүрс" ХХК-ийн төслийн менежер;<br>o 2010 оноос "Талст Маргад' ХХК-ийн захирал;<br>o 2012-2014 онд "Гутал" ХК-ийн ТУЗ-ын дарга.<br>o 2014-2018 онд "Нурамт Холдинг" ХХК-ийн гүйцэтгэх захирал |
| 3. | Чимэддоржийн ЦЭЦЭГМАА<br>1956 онд төрсөн | 1981 онд Москва улсын Лениний нэрэмжит Багшийн их сургуулийг төгссөн | o 1981- -1986 онуудад Политехникийн их сургуульд орос хэлний багш<br>o 2000-2010 онуудад Монголын Хараагүйчүүдийн Холбоо<br>o Гутал ХК-ийн ТУЗ-ийн гишүүн |
| 4. | Батбаярын БАТТӨР<br>1985 онд төрсөн | 2002-2007 онд АНУ-ын Колорода сурч байсан<br>2010 онд Өмнөд Австралид Аделете хотын их сургууль | o 2007-2008 онд БХЯаманд мэргэжилтэн<br>o 2010 оноос одоог хүртэл "Спейшл майнз" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. |
| 5. | Батбаярын БАТБИЛЭГ<br>1980 онд төрсөн | 2002 онд АНУ-ын Baruch College New York хөрөнгө оруулалт санхүүжилт бакалавр<br>2002-2007 онд Төрийн албаны зөвлөлд мэргэжилтэн, ахлах референт | o 2008-2009 онд "Кашмир Консепт" ХХК-д захирал<br>o 2009-2010 онд "Эрдэнэс Монгол" ХК-д ахлах эдийн засагч<br>o 2010-2015 онд Эрдэнэс Таван толгой ХК-д IPO төслийн удирдагч, газрын захирал, гүйцэтгэх захирал хийж байсан. |
| 6. | Төмөрийн БИЛЭГТ<br>1995 онд төрсөн | Английн Бристолийн Их сургуулийг инженер бакалавр | o ДиБи Интернэшнл ХХК-ийн гүйцэтгэх захирал |

ХАРААТ БУС ГИШҮҮД:

| № | Овог нэр | Төгссөн сургууль | Туршлага |
|---|---|---|---|
| 1. | Энхболдын БИЛГҮҮН 1984 онд төрсөн | 2006 онд Их Засаг их сургуульд Олон улсын эрх зүй бакалавр | o 2006-2011 онд “Си Эй Эм Эл” ХХК Гэрээ хариуцсан менежер<br>o 2014 оноос одоог хүртэл “Өмгөөллийн Монгол Өмгөөлөгч” ХХН, Зөвлөх үйлчилгээний секторын ахлах, ахлах өмгөөлөгч |
| 2. | Сүхбатын БАТ-ЭРДЭНЭ 1986 онд төрсөн | 2007 онд МУИС-ийн Геологи, Газар зүйн Ухааны сургуульд Эрдэс баялаг , хайгуулын эдийн засагч бакалавр | o 2007 онд Пибоди Энержи ХХК-д туслах геологи<br>o 2008-20012 онд Талст Маргад ХХК-д Төслийн менежер<br>o 2013 онд Сентино Лайтинг ХХК-д төслийн менежер<br>o 2018 оноос Нурамт Холдинг ХХК-д ерөнхий менежер<br>o 2021 оноос Кашмир Консепт ХХК-д Гүйцэтгэх захирал |
| 3. | Бавуусүрэнгийн ЖАРГАЛ 1968 онд төрсөн | 1992 онд Уралын улсын их сургуулийг Санхүүч, Эдийн засагч<br>1999 онд МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийг Нягтлан бодогч<br>2012 онд Монгол Улсын хугацаагүй эрхт мэргэшсэн нягтлан бодогч<br>2013 онд Татварын мэргэшсэн зөвлөх<br>2015 онд Аудитор | o 1995-2000 онд Нийслэлийн Татварын Газарт Эдийн засагч, татварын улсын байцаагч<br>o 2000-2008 онд Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэст Татварын улсын байцаагч<br>o 2008-2014 онд Татварын Ерөнхий Газарт Татварын улсын байцаагч<br>o 2015-2017 онд Мандах мотиваци аудит ХХК-д Аудитор, Партнер<br>o 2018-аас өдгөөг хүртэл Фитакон аудит ХХК-д Аудитор, Партнер |

*Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 сарын 20-ний өдрийн
2 тоот тогтоолын Хавсралт 04*

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ

| № | Зардал | Сарын цалин /төгрөг/ | Тоо | Бүгд /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн дарга | 5 000 000 | 1 | 60 000 000 |
| 2 | ТУЗ- ийн гишүүн | 1 000 000 | 8 | 96 000 000 |
| 3 | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 800 000 | 1 | 9 600 000 |
| 4 | ТУЗ-ийн үйл ажиллагаа, бичиг хэрэг | жилд | | 2 700 000 |
| | **Нийт** | | | **168 300 000** |

# “ГУТАЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026.__.___ Дугаар ___ Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2026 оны __ дүгээр сарын ___- ний өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн ... %- ийн саналаар батлалсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.БАТБИЛЭГ

## "ГУТАЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026.__.___ Дугаар ___ Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь хэсэг, 62.1.13 болон 2026 оны ....... дүгээр сарын .... - ний өдрийн тооллогын комиссын ......... дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

   1.
   2.
   3.
   4.
   5.
   6.

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

   1.
   2.
   3.

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4. "Гутал" ХК-ийн 2026 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу ... хувийн саналтай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА ___________________

# “ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026.__.__ № Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилалтын тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон 2026 оны .... дүгээр сарын ....... - ний өдрийн тооллогын комиссын .......... дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01 тоот тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 3230 /гурван мянга хоёр зуун гучин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд танилцуулсаныг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА ____________________

*Гутал" ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 сарын 20-ний өдрийн*
*2 тоот тогтоолын Хавсралт №1*

**"ГУТАЛ" ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

"Гутал" ХК- ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 29-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Гутал ХК-ийн байранд, 2 давхарт ТУЗ-ийн хурлын танхимд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог: ......................................... нэр: ...........................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: .................. Регистрийн дугаар: ................................
Санал өгөх хувьцааны тоо: ................
Бүртгэсэн: ........................................................................................................................
/Үнэт цаасны компанийн нэр/
Брокерийн овог: ............................................ нэр: ..................................................

| Хурлаас гаргах шийдвэр | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|
| 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах | | | |
| 2. 2026 оны ТУЗ-ийн төсөв батлах | | | |
| 3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох | Кумулятив аргаар өгсөн саналын тоо | | |
| Ердийн гишүүнээр | | | |
| 1. Т.Билэгт | | | |
| 2. Б.Баттөр | | | |
| 3. Ч.Цэцэгмаа | | | |
| 4. Б.Батхишиг | | | |
| 5. Ц.Төмөр | | | |
| 6. Б.Батбилэг | | | |
| Хараат бус гишүүнээр | | | |
| 1. Э.Билгүүн | | | |
| 2. Б.Жаргал | | | |
| 3. С.Бат-Эрдэнэ | | | |

Хувьцаа эзэмшигч ..............................  /гарын үсэг/

Тооллогын комиссын дарга....................................../гарын үсэг/

Гишүүд........................................... /гарын үсэг/

........................................... /гарын үсэг/

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал өгөх куммулятив аргыг ашиглана. Энэ аргаар санал өгөхдөө эзэмшиж буй хувьцааныхаа тоог 6-аар үржүүлж гарсан тоог ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнд дурын харьцаагаар хувааж өгнө. Харин хувьцаанхаа тоог 3-аар үржүүлж гарсан саналын тоог хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 3 хүнд дурын харьцаагаар хувааж саналаа өгнө. Тухайлбал, таны эзэмшиж буй хувьцааны тоо 100 гэвэл 600 саналыг ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнээс нэг хүнд бүгдийг нь өгч болно, эсвэл нэгэнд нь 500 саналаа 2 дахад нь 100 саналаа гэх мэтээр ямарч харьцаагаар хувааж өгч болно. 300 саналаа хараат бус гишүүнд нэр дэвшиж буй нэг хүнд бүгдийг нь эсвэл 3 хүнд адилхан 100 санал өгөх мэтээр хувааж өгч болно. Гэхдээ хараат бус гишүүнд нийт саналынхаа 1/3-ийг ердийн гишүүнд нийт саналынхаа 2/3-ийг өгсөн байх ёстой. Ингээгүй бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө. Энэ тохиолдолд саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.
4. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болгон үнэт цаасны хадгаламжийн дансны хуулгыг хамт өгч явуулна.
   Таныг төлөөлөх хүний овог: .........................................
   нэр: .................................................................
   Оршин суугаа хаяг: .........................................................................................................
   Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 99044612 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан: ........................................................................

**"ГУТАЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 10 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46, 47-р зүйлийн холбогдох заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг, 2025 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 10-ний өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2025 оны цэвэр ашиг, мөн үеийн санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн зохистой харьцаа зэргийг үндэслэн нэгж хувьцаанд 3230 /гурван мянга хоёр зуун гучин/ төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилсугай

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 13-ний өдрөөр тогтоосугай

3. 2025 оны ногдол ашгийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлэн холбогдох хууль, журмын дагуу олгохыг Ерөнхий Захирал Ц.Төмөр-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.БАТБИЛЭГ

ГУТАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
9020040448 2075423
ULAANBAATAR MONGOLIA